ШИНЖЛЭН
МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

"ОРХОН ХӨГЖИЛ" ХК-ИЙН 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

info@shinjlenmagadlakhui-audit.mn

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Авзага трейд байр, 703 тоот

9919-7346, 7511-0000

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1.	Хараат бус аудиторын тайлан	1-3
2.	Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл	4
3.	Санхүүгийн үзүүлэлтүүд	5-10
4.	Тайлан бэлтгэсэн үндэслэл	11
5.	Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого	12-17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АОУС	Аудит Олон Улсын Стандарт
НББОУСЗ	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТТХ	Санхүүгийн Тайлагналын Тайлбарын Хороо
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
ҮАБО	Үйл ажиллагааны бус орлого
НЭЗХЭ	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-13/3, Авзага трейд байр, 703 тоот
Утас: 99197346, 75110000
Цахим хаяг: info@shinjlenmagadlakhui-audit.mn

2026.10.18 № 164-02/26

танай_____-ны _____-т

"ОРХОН ХӨГЖИЛ" ХК-ИЙН УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид "ОРХОН ХӨГЖИЛ" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31- нээрх Санхүүгийн байдал, Орлого үр дүн, Цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлан тодруулгад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг талаараа "ОРХОН ХӨГЖИЛ" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдал, Үр дүн, Цэвэр хөрөнгийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ууд болон Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомжуудын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудит хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их анхаарал татсан асуудлууд байдаг.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС 1

Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлсэн залруулах зүйл гараагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь тухайн байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Уг үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудит нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаарх аудитын нотолгоо олж авах зориулалтаар гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгож авсан горимууд нь аудиторын үнэлэмжээс хамаарах бөгөөд үүнд залилан юм уу алдаанаас үүдэлтэй санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС

үнэлгээ багтдаг. Эрсдэлийн энэхүү үнэлгээг хийхдээ аудитор аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг зохиох зорилготойгоор аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "ОРХОН ХӨГЖИЛ" ХК-ийн удирдлагад зориулан бэлтгэсэн ба бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **С. ОРГИЛ**

УЛААНБААТАР ХОТ ШИНЖЛЭН МАГАДЛАХ ЭЗШ АУДИТ ХХК 9023100240 8339929

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК

ХУУДАС ... 3

1. БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үйлчлүүлэгч байгууллагын нэр	"ОРХОН ХӨГЖИЛ" ХК
Үүсгэн байгуулах шийдвэр:	2006.02.13-ны өдрийн 01 тоот шийдвэр
Улсын бүртгэлд бүртгүүлсэн байдал: ➢ *Улсын бүртгэлийн дугаар* ➢ *Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо* ➢ *Регистрийн дугаар*	➢ ➢ 2006.02.13 ➢ **2054787**
Үндсэн үйл ажиллагааны чиглэл:	➢ 1061 - Үр тарианы гурил үйлдвэрлэл ➢ 4610 - Гадаад дотоод худалдаа ➢ 4923 - Хуурай замын ачаа тээвэрлэх үйлчилгээ ➢ 0111 – Газар тариалан
Хувьцаа эзэмшигчид:	➢
Гүйцэтгэх удирдлагын баг: ➢ *Гүйцэтгэх захирал*	➢ *Г.Түвшинбилэг*
Үйл ажиллагаа явуулдаг байгын хаяг:	➢ Сэлэнгэ, Орхонтуул, 1-р баг, Рашаант, 01
Харилцах утасны дугаар:	➢
Өмнөх аудитын байгууллага:	➢
Аудитын төрөл:	➢ *Хуулийн дагуу*

ТАЙЛАНТ ОНЫ АУДИТ:

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ" ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-13/3,
Авзага трейд байр, 703 тоот

Утас: 7511-0000

Email: info@shinjlenmagadlakhui-audit.mn

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС

1.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,846,495.51	1,108,631.44
Дансны авлага	1,125,292,286.00	1,016,980,286.00
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	869,851.00	2,209,280.00
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	304,864,864.52	371,683,300.06
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	**1,432,873,497.03**	**1,391,981,497.50**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	821,499,206.05	707,210,600.06
Биет бус хөрөнгө	-	-
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**821,499,206.05**	**707,210,600.06**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**2,254,372,703.08**	**2,099,192,097.56**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	32,265,000.00	16,410,000.00
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	15,395,960.85	56,609,853.26
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	750,000,000.00	300,000,000.00
Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	1,114,310.00	1,114,310.00
Урьдчилж олсон орлого	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Богино хугацаат өр төлбөр	381,067,605.31	321,577,961.61
Бусад	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**1,179,842,876.16**	**695,712,124.87**
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС . 5 .

Өр төлбөрийн нийт дүн	**1,179,842,876.16**	**695,712,124.87**
2. Эзэмшигчийн өмч	-	-
Өмч: -төрийн	-	-
- хувийн	104,518,930.00	104,518,930.00
- хувьцаат	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмч бусад хэсэг	174,478,868.00	174,478,868.00
Хуримтлагдсан ашиг:	795,532,028.92	1,124,482,174.69
Тайлант хугацааны	-	-
Эздийн өмчийн дүн	**1,074,529,826.92**	**1,403,479,972.69**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**2,254,372,703.08**	**2,099,192,097.56**

1.2 ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	812,940,024.68	1,170,343,999.44
Борлуулалтын өртөг	210,654,329.00	237,637,062.02
Нийт ашиг /алдагдал/	**602,285,695.68**	**932,706,937.42**
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	33,407.60	71,689.58
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	330,644,296.28	312,496,442.10
Санхүүгийн зардал	-	72,876,962.74
Бусад зардал	184,558,792.32	150,194,457.94
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,390.99	56,475.16
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	**87,120,405.67**	**397,267,239.38**
Орлогын татварын зардал	13,583,740.35	54,733,353.26
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Бусад олз (гарз)	-	-
Татварын дараах ашиг (алдагдал)	**73,536,665.32**	**342,533,886.12**
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	**73,536,665.32**	**342,533,886.12**

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС 6

1.3 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31			-		-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	(53,595,864.00)	**(53,595,864.00)**
Залруулсан үлдэгдэл	**104,518,930.00**	**-**	**-**	**-**	**174,478,868.00**	**721,995,363.60**	**1,000,993,161.60**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	73,536,665.32	**73,536,665.32**
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31	**104,518,930.00**	**-**	**-**	**-**	**174,478,868.00**	**795,532,028.92**	**1,074,529,826.92**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	(13,583,740.35)	**(13,583,740.35)**
Залруулсан үлдэгдэл	**104,518,930.00**	**-**	**-**	**-**	**174,478,868.00**	**781,948,288.57**	**1,060,946,086.57**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	342,533,886.12	**342,533,886.12**
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2025 оны 12-р сарын 31	**104,518,930.00**	**-**	**-**	**-**	**174,478,868.00**	**1,124,482,174.69**	**1,403,479,972.69**

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗЭН АУДИТ ХХК
ХУУДАС №

1.4 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 он	2025 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	**812,973,432.28**	**1,134,066,921.02**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	812,940,024.68	1,133,995,231.44
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	33,407.60	71,689.58
Мөнгөн зарлагын дүн (-)	**441,024,025.04**	**580,828,616.55**
Ажилчдад төлсөн	54,663,592.00	66,878,250.50
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,371,800.00	9,991,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	201,654,329.00	146,927,620.00
Ашиглалтын зардалд төлсөн	2,159,113.00	4,346,617.00
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	75,216,795.00	191,336,736.00
Хүүний төлбөрт төлсөн	26,673,070.69	120,683,562.24
Татварын байгууллагад төлсөн	63,017,020.50	36,300,662.70
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	5,268,304.85	4,364,168.11
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**371,949,407.24**	**553,238,304.47**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	**512,463,770.00**	**117,312,000.00**
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	512,463,770.00	117,312,000.00
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Бусад орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	**814,482,110.00**	**146,000,000.00**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	121,331,800.00	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	693,150,310.00	146,000,000.00
Бусад	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(302,018,340.00)**	**(28,688,000.00)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		
Мөнгөн орлогын дүн (+)	**607,448,870.92**	**579,116,212.97**
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	607,424,000.00	579,055,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Валютын ханш	-	-

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС . 8

Бусад	24,870.92	61,212.97
Мөнгөн зарлагын дүн (-)	**675,920,479.93**	**1,104,404,381.51**
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	675,900,000.00	1,104,399,643.70
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Бусад	20,479.93	4,737.81
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(68,471,609.01)**	**(525,288,168.54)**
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**1,459,458.23**	**(737,864.07)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**387,037.28**	**1,846,495.51**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**1,846,495.51**	**1,108,631.44**

2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

2.1. СТОУС-ын нийцэл

Тус компанийн санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд нарийвчлан харуулж тайлагнасан. СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг ба санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол, түүний нөлөөллийн талаар тайлангийн хэсэгт тодруулсан.

2.2. Хэмжилтийн үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлгууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харах) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөг суурилан бэлтгэгдсэн.

- Санхүүгийн хөрөнгө-Зээл ба авлага хорогдуулсан өртгөөр илэрхийлэх;
- Санхүүгийн өр төлбөр-Санхүүгийн өр төлбөр, хорогдуулсан өртгөөр илэрхийлэх;
- Санхүүгийн бус хөрөнгө-Түүхэн өртгөөр илэрхийлэх;

2.3. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тасралтгүй байх зарчмын дагуу өөрийн үйл ажиллагааг төлөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага үйл ажиллагааны хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

ШИНЖЛЭХ МЭРГЭЛЛИЙН ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС ..9

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО

3.1. Санхүүгийн хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд гар дээрх мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердравт багтана. Банкны овердравтыг балансын эргэлтийн хөрөнгийн хэсэгт харуулна

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдалд тайлагнана.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд хэмжих зорилгоор дараах байдлаар ангилна:

A. Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих
   Зээл ба авлагууд нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм.

B. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тайлант үеийн ашиг алдагдлаар бүртгэгдэх

   Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө нь арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан аваад богино хугацаанд эргүүлэн худалдах зоруулалттай хөрөнгө болон анхнаасаа бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгүүдээс бүрдэнэ. Идэвхитэй зах зээлийн үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилахгүй.

C. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх

   Тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр ба тогтсон хугацаа байхгүй, дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалт болон өмнө дурдсан ангиллуудын алинд ч багтаагүй санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд багтаана.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС ...10

3.2. Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлаар
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн хувьд дансны үнийн бусад өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана. Үр ашигт хүүний аргаар тооцсон хөрөнгө оруулалт болон зээл ба авлагын хүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.
Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- Түвшин 1 — Хөрөнгө, өр төлбөрийн хувьд идэвхтэй зах зээл, Тухайлбал: арилжаа солилцооны зах зээл, Дилерийн зах зээл, Брокерийн зах зээл, Оролцогчдын хоорондын зах зээл;
- Түвшин 2 - Бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх шууд ба шууд бус мэдээлэл: Тухайлбал: Лайбор-ийн ханшид суурилсан, тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх түүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшинд суурилсан, тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп;
- Түвшин 3 - Бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэ мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашиглагдаагүй бусад аргачлалууд;

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан; эсвэл
- Байгууллага нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд (а) санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн; эсвэл (б) бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх;

Бодит үнэ цэнийн хэмжилтийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэхээр ангилагдсан санхүүгийн хөрөнгийг зарсан бол бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан бодит үнэ цэнийн тохируулгыг ашиг, алдагдлын тайланд хөрөнгө оруулалтын үнэт цаас борлуулсны олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЭШ АУДИТ ХХК

3.3. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

(i) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө

Тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан гм)-тай холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

(ii) Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө

Бодит хөрөнгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг
бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй.
Бодит үнэ цэнийн хэмжилтийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтын өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

3.4. Санхүүгийн өр төлбөр

Байгууллага ар телберийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр ангилдаг.

- ❖ Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ❖ Бусад санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг , алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүстэн хэргэлүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

3.5. Үндсэн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөх ба хэмжилт

Бүх үндсэн хөрөнгө дараа үед түүхэн өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгагдана. Анхдагч хэмжилтийн өртөг хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана. Мөн өртөгт гадаад валютаар худалдан авсан үндсэн хөрөнгийн мөнгөн урсгалын олз/гарзын өмчийн дүнгээс шилжүүлсэн хэрэг болно.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг оруулсан үед дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээний холбоотой гарсан зардлыг гарсан үед тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулсан тодорхойлсон ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

Дараа үеийн зардал

Сольж тавьсан эд анги, хэсэг нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж байгууллагад өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг тайланд хөрөнгийн дансны үнэнд нэмж хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Барилга, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг ба элэгдүүлэх хугацааг доор харуулсан болно.

- Барилга байгууламж 30-40 жил
- Тавилга эд хогшил 5-10 жил
- Тоног төхөөрөмж 10 жил

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭДИТ АУДИТ ХХК
ХУУДАС: 13

- Тээврийн хэрэгсэл 10 жил
- Компьютер дагалдах хэрэгсэл 3-5 жил
- Бусад хөрөнгө 10 жил

3.6. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэнэ буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно. Үнэ цэнийн бууралтыг шалгахдаа хөрөнгүүдийг бүлэглэх ба ингэхдээ бусад хөрөнгүүд болон мөнгө үүсгэгч нэгжүүдээс орох мөнгөн орох мөнгөн урсгалаас ангид, дангаараа цаашид үргэлжлүүлэн ашигласнаар мөнгөн орох урсгал бий болгох хөрөнгүүдийн хамгийн жижиг бүлэг байхаар бүлэглэнэ.

Тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүнгийн аль ихээр тооцно. Ашиглалтын үнэ цэнэ нь татварын өмнөх дискаунтын түвшин (мөнгөний үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн эрсдэл зэргийг агуулсан)-г ашиглан ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно.

Хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс ил бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

3.7. Цэвэр хөрөнгө

Нөөц

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч юм. Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч юм.

Хуримтлагдсан үр дүн

Үүсгэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд тус байгууллагад хуримтлагдсан эерэг, сөрөг үр дүнгийн нийлбэрийг хуримтлагдсан үр дүн дансанд бүртгэх ба анхны оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

3.8. Орлого

Орлогыг үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас үүссэн орлого нь бараа бүтээгдэхүүний борлуулалт болон түүнтэй холбоотой үйлчилгээний орлогоос бүрдсэн үед хүлээн зөвшөөрнө.

- ✓ Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой байх;

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС

- ✓ Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай байх;
- ✓ Балансын өдрөөр тухайн ажил гүйлгээний иж бүрдэлийн үе шатыг бодитойгоор тооцох боломжтой;
- ✓ Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал болон ажил гүйлгээг гүйцээхэд гарсан өртгийг найдвартай хэмжих боломжтой байх;

Хүүний орлого

Хүүний орлогыг үндсэн зээл буюу хэрэглүүрийн үлдэгдэл болон холбогдох харилцах хадгаламжийн үлдэгдлээс үр ашигтай хүүний түвшнээр тооцож, аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө.

3.9. Зардал

Тайлант хугацаанд мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг тухайн гарсан жилд нь үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

3.10. Санхүүгийн орлого зардал

Санхүүгийн орлогод харилцах, хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүүний орлого, бараа бүтээгдэхүүн борлуулсаны орлог зэргийг хамруулна. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан орлого олсон тайлант үеийнх нь үр дүнгийн тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүний зардлыг хамруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлттэй шууд хамааралтай капиталжуулсан зээлийн өртгөөс бусад бүр зээлийн хүүний зардлыг үр ашигт хүүний аргыг ашиглан тайлант үеийнх нь үр дүнгийн тайлан тусгана.

Зээлийн хүүний зардал

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах эсвэл үйлдвэрлэхтэй шууд холбоотой тусгай болон ердийн зээлийн хүүний зардлыг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгох зорилгоор хөрөнгийг бэлтгэх болон бүрэн дуусгахад шаардлагатай хугацааны туршид капиталжуулна. Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгө гэдэг нь хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болтол тодорхой хугацаа шаардлагатай хөрөнгийг хэлнэ.

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг зарцуулалтанд тодорхой зээл авч богино хугацааны хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтын орлогыг капиталжуулах зээлийн хүүний зардлаас хасна.

Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон авлага, өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө , өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг.Гадаад валютаар илэрхийгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаадад валютын ханшийн зөрүүг ерөнхийдөө ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Зээлтэй холбоотой ханшийн зөрүүний олз, гарзыг үр дүнгийн тайланд санхүүгийн зардалд багтаан тайлагнана. Бусад ханшийн зөрүүний олз, гарзыг үр дүнгийн тайланд бусал орлого эсвэл бусад зардлын цэвэр дүнгээр тайлагнана.

3.11. Түрээс

Түрээсийн үүрэг хариуцлагыг санхүүгийн зардлыг хассан цэвэр дүнгээр нь бусад богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн хэсэгт харуулдаг. Түрээсийн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн зардал гэсэн 2 хэсэгт ангилна. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид үр дүнгийн тайланд тусгах ба тайлант хугацаа бүрийн хувьд өр төлбөрийн үлдэгдэлд тооцогдох тогтмол хугацааны хүүг тооцоолох шаардлагатай. Санхүүгийн түрээсээр олж авсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаанд эсвэл түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хэрэнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ.

Түрээсийн хөрөнгийн эрсдэл ба өгөөжийн дийлэнх хувийг хүртэхээргүй бол үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг. Үйл ажиллагааны түрээсийн төлбөр (түрээслүүлэгчээс үзүүлсэн урамшууллыг хассан цэвэр дүнгээр)-ийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар үр дүнгийн тайланд тусгана.

3.12. Ажилчдын тэтгэмж

Ажилтан байгууллагад үзүүлсэн үйлчилгээний хариуд тайлант үеийн эцсээс хойших арван хоёр сарын хугацаанд багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмж болох цалин, хөлс болон мөнгөн бус тэтгэмжүүдийг тайлант хугацааны эцсийг хүртэлх хугацаанд үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр хэмжинэ.

Ажилтны үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас хойш арван хоёр сараас илүү хугацаанд төлөгдөх бусад урт хугацааны тэтгэмжид удаан жил ажилласны тэтгэмж болон жилийн амралт зэрэг багтах ба төлөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглан тайлант жилийн эцэс хүртэл үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр дэмжинэ.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС

Стандартаар заасан бусад хэлбэрүүд болох ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдсаны тэтгэмж нь Монгол улсын холбогдох хуулийн дагуу төрөөс төлөгддөг бөгөөд байгууллагын хувьд төлбөр төлөх үүрэг хүлээдэггүй.

3.13. Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын үр дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэх, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хэлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

3.14. Татварын бүртгэл

Аж ахуйн нэгж байгууллагын албан татвар төлөгч, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгч байгууллага юм. Байгууллагын ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол улсын “Нийгмийн даатгалын тухайн” хуулийн дагуу, хувь хүний орлогын албан татварыг “ Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тогтоосон хувь хэмжээгээр суутган авч харьяалагдах татвар, нийгмийн даатгалын хэлтэст төлж тайлагнана. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэгдэнэ.

3.15. Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. СТОУС-аар байгууллага нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой тал болох ба хэрвээ тухайн этгээд нь өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

Тодруулга – Болзошгүй зүйл

2025 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ ХХК

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК
ХУУДАС 47